



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 онь 05 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх
аргачилсан зөвлөмж батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн
23.3.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ыг мөрдөж хэрэгжүүлэхэд энэхүү аргачилсан зөвлөмжийг арга зүйн удирдамж чиглэл болгохыг итгэмжлэл авсан байгууллагын удирдлага, ажил олгогч нарт зөвлөсүгэй.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА,
ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ю.ИДЭРЦОГТ

ХАБЭА-н Үндэсний хорооны 2016 оны 5 дугаар сарын 30 өдрийн 01 тоот тогтоолын хавсралт.



Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
хийх аргачилсан зөвлөмж

Ерөнхий зүйл

1. Энэхүү зөвлөмжийн зорилго нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх ажлын зохион байгуулалт, үзүүлэлт, үнэлгээ хийх дэс дараалал, үнэлгээний үр дүнг тооцох аргачлалын талаар арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

2. Ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд шаардлагатай баримт бичиг, мэдээлэл, тайлбарыг ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллагад гаргаж өгнө.

3. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллага нь Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу Стандартчилал, хэмжил зүйн газраас итгэмжлэл авч, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвд бүртгүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байна.

4. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх явцад үнэлгээ хийж байгаа байгууллагын ажилтны эрүүл мэнд, амь насанд аюул учруулахаар нөхцөл бий болсон тохиолдолд үнэлгээ хийхээс татгалзах, ноцтой зөрчлийг арилгуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар ажил олгогч болон хөдөлмөрийн хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

5. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг дараах зорилгоор ашиглана.

5.1. хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;

5.2. ажилтнуудад ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, хортой, аюултай хүчин зүйлээс эрүүл мэндэд учрах эрсдэл, түүнээс хамгаалах арга замын талаар мэдээлэх;

5.3. ажлын байранд ажилтныг нийтийн болон хувийн хамгаалах хэрэгслээр хангах;

5.4. хөдөлмөрийн нөхцөлд дотоодын хяналт хийх;

5.5. эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэг зохион байгуулах;

5.6. хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн ангиллаар газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлөөр хөнгөлөлт үзүүлэх;

5.7.нэмэлт даатгалд хамруулах;

5.8.хөдөлмөрийн нөхцөлийн мэдээллийн сан бүрдүүлэх;

5.9.мэргэжлийн өвчнийг тогтоох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж, тогтоох;

5.10.ажил олгогч, ажилтны хооронд хөдөлмөрийн нөхцөлийн асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэх;

5.11.аюултай ажил үүрэг гүйцэтгэхийг хязгаарлах, тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх шийдвэр гаргах;

5.12.ажлын байрны буюу мэргэжлийн эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг болно.

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх дэс дараалал

1.Үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийг тодорхойлох

1.1. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллагын шинжээч нь ажлын байрны хортой, аюултай хүчин зүйлийг илрүүлж, үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлд хамаарах, хэмжилт шинжилгээ явуулах эсэхийг тогтоож, баримтжуулна.

1.2.Үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийг тухайн үйлдвэрийн барилгын зураг төсөл, ажилтны ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмжийн техникийн баримт бичиг, үйлдвэрлэлийн технологийн заавар, үйлдвэрлэлд хэрэглэх түүхий эд, материал, химийн бодис, тэдгээрийн хоруу чанар, хор аюулгүйн лавлах мэдээлэл, ажилтны ажлын байрны тодорхойлолт зэргийг ажил олгогчоос гаргуулан авч, судлан үзсэний үндсэн дээр тодорхойлно. Мөн ажилтны ажлын байранд үзлэг хийх, ажилтай нь танилцах, асуумж судалгаа авах замаар тодорхойлж болно.

1.3.Тодорхойлсон хүчин зүйлүүд нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2000” стандартад заасан хүчин зүйлийн нэршилтэй тохирох ба хэмжигдэхүйц байна.

1.4.Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээ хийж,ажлын байр тус бүрээр хүчин зүйлийг тогтоож, баталгаажуулна.

2. Үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийг хэмжиж шинжлэх, үнэлэх

А. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд дараах хэмжилт шинжилгээ, үзүүлэлтүүд хамаарна. Үүнд:

1.агаарын температур

2. агаарын харьцангуй чийглэг
3. агаарын хөдөлгөөний хурд
4. дуу, шуугианы түвшин
5. хэсгийн болон ерөнхий доргионы түвшин
6. ажлын гадаргуугийн гэрэлтүүлэг
7. ажлын байрны агаар дахь химийн бодисын ууршилтын хэмжээ
8. ажлын байрны агаар дахь аэрозол, тоосны хэмжээ, ширхэглэг
9. цахилгаан ба соронзон орны хүчдэл, хэт ягаан туяа, цацрагийн энергийн тун
10. лазерийн туяаны энергийн тун
11. гамма, рентген, нейтроны цацрагийн эквивалент тун, чадал
12. радио идэвхт бодисын бохирдол
13. ажлын байрны агаарт бичил биет тодорхойлох
14. хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад гарах биеийн хүчний ачаалал (биеийн хүчний динамик ачаалал, гараар өргөх, зөөх ачааны хэмжээ, ээлжинд гүйцэтгэх нэг маягийн хөдөлгөөний тоо, статик ачаалал, ажлын байрлал, их биеэр бөхийх хөдөлгөөний тоо, явж гүйцэтгэх орон зайн хэмжээ)
15. хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад гарах сэтгэл зүйн ачаалал (тусгай тоног төхөөрөмж ба холбооны хэрэгсэл, яриагаар нэг цагт хүлээн авч байгаа мэдээ, дохионы тоо (гэрлэн ба дуут), нэгэн зэрэг харах үйлдвэрлэлийн объектын тоо, оптикийн багажтай ажиллах хугацаа, дууны эрхтний ачаалал (7 хоногт ярих цаг), дахин давтан хийх ажилбарын тоо)
16. агаар сэлгэлтийн системийн үр ашиг
17. хувийн хамгаалах нэг бүрийн хэрэгслийн үр ашиг зэрэг болно.

Б. Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээг хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлээс хамаарч хийнэ. Үүнд:

1. хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх байгууллагын лабораторид хийж гүйцэтгэх боломжгүй хэмжилт шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийлгүүлэх, мөн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгүүлэхээс өмнөх 6 сарын хугацаанд итгэмжлэгдсэн лабораторийн хийсэн дүнг ашиглаж болох ба тус лабораторийн газраас зөвшөөрөл авч, дүгнэлт гарган хавсаргана.

2. хэмжилт шинжилгээг Монгол Улсын стандартаар батлагдсан болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. хэмжилт шинжилгээнд эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн лабораторид, эсвэл тухайн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс баталгаажуулсан багаж хэрэгсэл ашиглах ба багажийн үзүүлэлт нь хэмжлийн нэгжийн олон улсын СИ системийн нэгжээр хэмжигдэнэ.

4. ижил төрлийн ажлын байранд 5 хүртэл ажилтан ажиллаж байгаа бол 100 хувь, 5-аас дээш ажилтан байвал ажилтны тоо, ажлын шинж чанараас хамааруулан 10-30 хүртэл хувийг хэмжилт шинжилгээ, судалгаанд хамруулна.

5. ажлын байрны агаар дахь тоосны сорьцыг талбайн болон амьсгалын бүсийн гэсэн 2 аргаар авах ба талбайн сорьцын үр дүнг агааржуулалтын тоног төхөөрөмжийн үр ашиг, бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.

6. хувь хүний амьсгалын бүсээс цуглуулсан тоос болон химийн бодисын хэмжилтийг ажлын ээлжийн 8 цагт, 3-аас доошгүй ээлжийн хугацаанд нэг цэгт 2-оос доошгүй удаа хэмжиж, дүнг ээлжийн дундаж ба хамгийн их үзүүлэлтээр гаргана. Хэмжилтийн дундаж хэмжээний тооцооны болон магадлалын алдаа, хазайлтыг статистик тооцооллын аргыг ашиглан тодорхойлно.

Ээлжийн дундаж хэмжээ- ажлын ээлжийн 8 цагийн хугацааны дундаж хэмжээг хэлнэ.

Хамгийн их хэмжээ- химийн бодисын ууршилтийн сорьцыг 15, тоосны сорьцыг 30 минутын хугацаанд авахад хамгийн их гарсан хэмжээг хэлнэ.

7. тоос, химийн бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, ангиллыг тооцохдоо “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2015”, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2015 оны А/356/396 дугаар тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодисын ангилал”-ыг ашиглана.

8. Ажлын ээлжийн хугацаанд /ажлын 5 хоногт/ тоостой ажлын байранд сэлгэн ажиллаж байгаа бол жилд авах тоосны ачааллыг тодорхойлж болно.

$$TA_{1\text{жил}} = K_{\text{эд}} * \text{Э/тоо} * Q \quad (1)$$

Энд:

$K_{\text{эд}}$ – Хувь хүний ажлын бүсийн агаар дахь тоосны хэмжээ мг/м^3 ;

Э/тоо – тухайн жилд сорвижуулах үйлчилгээ бүхий тоостой нөхцөлд ажилласан ээлжийн тоо;

Q – нэг ээлжийн хугацаанд уушигний агаарын эзлэхүүн, л/м^3 тооцохдоо “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны

орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990 : 2015” стандартад заасан ажлын төрлийн ангиллыг ашиглах ба Ia-Iб төрлийн ажлын үед – 4м^3 ; IIa-IIб төрлийн ажлын үед – 7м^3 ; III төрлийн ажлын үед – 10м^3 байна.

9. жилийн тоосны ачааллыг хяналтын тоосны ачаалал ХТА / (Ээлжийн дундаж тоог эрүүл ахуйн зөвшөрөгдөх дээд хэмжээ, болон уушигны агаарын эзлэхүүнээр үржсэнтэй тэнцэх ба $\text{ХТА}=\text{ЗДХэд} \cdot \text{Э}/\text{тоо} \cdot \text{Q}$)-тай харьцуулна.

10. хоёр ба түүнээс дээш төрлийн тоос хэмжигдсэн бол зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь бага байгаа тоосыг авч үзнэ.

11. ажлын байрны агаарт бичил биет тодорхойлж болох ба гоц халдварт өвчний үүсгэгчтэй харьцан ажилладаг, бусад халдварт өвчин үүсгэгчтэй харьцан ажиллаж байгаа ажилтнууд, патоанатоми, задлан шинжилгээний ажилтнууд, боловсруулаагүй арьс ширтэй харьцан ажиллах, мал нядалгаа, цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээний ажилтнуудын ажлын байрны агаарт шинжилгээ хийх шаардлагагүй, стандартад заасан ангилалд шууд хамааруулна.

12. шуугианы эх үүсвэр, давтамж, ажлын байрлалаас хамаарч шуугианы суурь болон дэлгэрэнгүй шинжилгээ, хувь хүний шуугианы тунг тодорхойлно.

13. бичил цаг уурын үнэлгээг ажлын байрны агаарын температур, агаарын харьцангуй чийглэг, агаарын урсгалын хурдаас гадна дулааны ачаалал, бодисын солилцооны эрчмийг үнэлэх үнэлгээ хийнэ.

18. ионжуулагч цацрагийн үнэлгээнд цацрагийн асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лабораторит хийсэн хэмжилт, шинжилгээний дүнг ашиглана.

19. 50 гц давтамжтай цахилгаан орон, 30МГц-300ГГц давтамжтай цахилгаан соронзон орон зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн бол аюултай ангилалд тооцно. Холбогдох стандарт, норм ба дүрмийг ашиглана.

20. хэмжилт шинжилгээний дүнг эрх бүхий байгууллагын баталсан маягтаар гаргаж, баталгаажуулсан байна./Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн/

21. хөдөлмөрийн үйл ажиллагааны хүнд хүчрийн үзүүлэлтийг ажлын 2-3 ээлжинд хэмжиж, дундаж үзүүлэлтийн хамгийн өндөр хэмжээгээр тооцно.

22. гараар өргөх, зөөх ачааны хэмжээг хэмжих хэрэгслээр жигнэх буюу, технологийн баримт бичигт байгаа хэмжээгээр тооцох ба зөөж байгаа ачааны массын хэмжээ/ эд зүйл, бүтээгдэхүүн, багаж хэрэгсэл гэх мэт/ хэрэв өөр өөр жинтэй бол тус тусад нь тоолж, ачааг 1 м, 1-5 м, 5 м-ийн зайд зөөсөн бол тус тусад нь зөөсөн ачааны массын хэмжээ, зөөсөн ачааны тоог тус тусад нь тоолж, тооцоолно. Жишээ:Эрэгтэй ажилтан 2,5 кг жинтэй эд ангийг дамжлагаас авч ажлын ширээ хүртэл 0,8 м зайд зөөж, холбогдох ажилбарыг хийж гүйцэтгээд буцаагаад дамжлагад оруулах ажил хийдэг, ажлын 8 цагт 1200 эд анги хийсэн гэж үзвэл $2,5 \cdot 0,8 \cdot 2 \cdot 1200 = 4800$ кг*м ачаалал гэж тооцно.

23. гар, сарвууны булчингаар хийх ажлын ачааллыг 10-15 минутын хугацаанд хөдөлгөөнийг тоолж нэг минутанд хийж байгаа хөдөлгөөний тоог гаргаад ээлжийн хугацааны минутаар үржүүлж тооцно.

24. гараар тогтоон барих ачааллыг ачааны хэмжээг тогтоон барьж байгаа хугацаагаар үржүүлж тооцно.

25. ажлын байрлалыг хронометражийн судалгаагаар хийнэ. Ажлын ээлжийн үргэлжлэх 8 цагийн хугацаанд ногдох ажлын байрлалын хувийг тооцоолно.

26. их биеэр бөхийж хийх ажлын нэгж хугацааны тоог тоолж, ажлын ээлжийн хугацаагаар үржүүлэх буюу эсвэл нэг хөдөлгөөнийг хийхэд зарцуулах хугацааг тоолж, хийсэн хөдөлгөөний тоогоор үржүүлнэ.

27. технологийн дамжлагын дагуу хэвтээ болон налуу гадаргуугаар явж гүйцэтгэсэн замын уртыг алхалт хэмжигчээр тооцох ба эрэгтэй хүний алхалт 0,6м, эмэгтэй хүнийхийг 0,5 м-ээр тооцож, алхалтын тоогоор үржүүлнэ. Үдийн цайны

амралтын хугацаанд алхалтыг тооцохгүй. Налуу гадаргуугийн өнцөг 30 градусаас ихгүй байна.

28. хөдөлмөрийн үйл ажиллагаан дахь сэтгэл зүйн ачааллын үзүүлэлтүүдийг хронометражийн судалгаа хийж тооцоолон хамгийн өндөр үзүүлэлтээр тооцно. Хөдөлмөрийн үйл ажиллагаан дахь сэтгэхүйн ачааллын үзүүлэлтийг тодорхойлохдоо тусгайлан боловсруулсан асуумж, сорил ашиглана.

3. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнг тооцох, тайлагнах

3.1. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ нь хэмжилт шинжилгээний бодит үзүүлэлт эрүүл ахуйн зөвшөөрөх норм, хэмжээ, түүнээс хэтэрсэн байдал, ажлын ээлжийн хугацаанд давтагдах давтамж, тухайн хүчин зүйлийн нөлөөлөлд өртөх хугацаа зэргээс хамаарна.

3.2. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхдээ ажлын байрны агааржуулалтын систем болон ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн үр ашгийг үнэлж, үнэлгээнд ашиглана.

3.3. Тухайн ажлын байранд ажиллаж байгаа ажилтнуудад хийсэн эрүүл мэндийн үзлэг, хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөлийн судалгаа, мөн тухайн хүчин зүйлээс шалтгаалан үүссэн мэргэжлийн өвчин, осол гэмтлийн бүртгэлд үндэслэн хүчин зүйл тус бүрээр эрсдэлийн магадлал, үр дагаврыг тооцоолон мэргэжлийн өвчний индекс үзүүлэлтийг ОУХБ, ДЭМБ-ийн зөвлөмжийг үндэслэн тодорхойлж болно. Мэргэжлийн өвчний индекс, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүнг хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд үндэслэл болгоно.

3.4. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн байгууллага нь үнэлгээ хийсэн ажлын байр тус бүрээр хэмжилт шинжилгээний дүн, агааржуулалтын систем болон ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн үр ашигт хийсэн дүгнэлтийг гаргаж, баталгаажуулсан байна.

3.5. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн байгууллага тайлангаа Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн захирлын тушаалаар баталсан тайлангийн маягтын дагуу гаргаж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний санал боловсруулан, тайлангийн хамт ажил олгогчид хүлээлгэн өгнө.

3.6. Ажил олгогч хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг ажилтнуудад танилцуулж, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.